

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ХЭРЭМТ ЦАМХАГ" УТҮГ-ЫН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ 2018/97/СТА-ТӨҮГ

2018 он

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.14 № 06/659
танай _____ -ны № _____ -т

“ХЭРЭМТ ЦАМХАГ” УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ЭРДЭНЭ ЖАРГАЛ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0314SAG11.Docx


070928
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ШШГЕГ-ын харъяа “Хэрэмтцамхаг” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан

Аудитын код: САГ-2018/97/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhortoosh@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: Атланта баланс аудит ХХК
Утас: 70115629 Цахим хаяг: Atlantaaudit@yahoo.com

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Орлого зардлын гүйцэтгэл, түүний талаархи мэдээлэл	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитаар илрүүлсэн алдаа. зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.10	Анхаарал татахуйц бусад асуудал	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.15	Санал, дүгнэлтийн хэлбэр үндэслэл	5
3	Менежментийн захидал	6
3.1	Татварын талаар	7
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	8-9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлтийн тайлан/	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12-13

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын захирал Т.Эрдэнэжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгч НӨАТ-ыг татвар төлөх хуулийн хугацаандаа төлөөгүй зөрчилд НӨАТ-ын хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж бичсэнийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Зөрчлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, батлагдсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 24-өөс 2018 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 13-нд эцэслэн баталгаажуулж,



“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Атланта баланс аудит” ХХК-ны ахлах аудитор П.Нямаа, аудитор А.Дэнсмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Атланта баланс аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх, үйлдвэрт ажиллах ялтныг мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох, хөдөлмөрөөр дамжуулан ялтанг нийгэмшүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанартай стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдийг хангахад оршино.

Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, салбарын тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангана.

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь сийрмэг бетон гулдмай үйлдвэрлэх, вакуум цонх, хаалга, хаалт үйлдвэрлэх гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улсын үйдвэрийн газар юм.

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.


2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аргазүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, /УСНББОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав. “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй 7 дансанд аудитын нарийвчилсан горим, сорил 19-ийг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Хэрэмт цамхаг” УТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/194 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангаа гаргасан байна.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар



төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Хэрэмт” УТҮГ нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. ШШГЕГ-гаас байгууллагын дотоод хяналт шалгалт хийх эрх бүхий алба хаагчийг ШШГЕГ-ын даргын тушаалаар анги, албадын дэд даргыг томиолсон. ШШГЕГ-ын хяналт шалгалтын тасгийн хяналт шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын хэлтсээс тодорхой чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулдаг байна.

2.6 Орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Хэрэмт цамхаг” УТҮГ-т ШШГЕГ-аас 392,200.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 578,500.0 мянган төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөө баталж өгсөн байна. Борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртгийг 392,100.0 мянган төгрөгөөр, удирдлагын зардлыг 76,747.0 мянган төгрөгөөр, ашгийг 187,300.0 мянган төгрөгөөр тус тус баталж, ШШГЕГ-т 100,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө өгсөн байна. 2017 онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 587,756.4 мянган төгрөг, бусад орлого 557.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлого 18,036.6 мянган төгрөг бүгд 606,317.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 490,802.7 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал 129,706.7 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 430,5 мянган төгрөг нийт 130,137.2 мянган төгрөгийн зардал гаргаж, 14,622.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан. ШШГЕГ-т төлөвлөгөөний дагуу 100,000.0 мянган төгрөг төвлөрүүлсэн нь татвар төлсний дараах ашгаас төвлөрүүлэх ёстой байсан бөгөөд энэ нь үйл ажиллагааны алдагдал болохгүй юм. ШШГЕГ-аас элэгдлийн зардал оруулаагүй бодит бус төлөвлөгөө баталж өгснөөс 100,000.0 мянган төгрөгийг ШШГЕГ-т төвлөрүүлж, 114,622.2 мянган төгрөгний алдагдалтай тайлагнасан байна.

Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 372 тоот тушаалаар ШШГЕГ-т 2,447,227.8 мянган төгрөгийг ШШГЕГ хувиарласан. ШШГЕГ нь хувиарласан мөнгийг Өвөрхангай аймаг дах ШШГГ-т нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих барилгыг 1,000,000.0 мянган төгрөгөөр барих, машин тоног төхөөрөмж худалдан авахад 1,574,145.8 мянган төгрөг зарцуулахаар санал оруулсан. Өвөрхангай аймагт барих барилгыг ШШГЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 4278 тоот тушаал, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд хийсэн гэрээгээр 879,827.8 мянган төгрөгийг төсөвт өртөгтэйгээр барихаар гэрээ хийсэн байна. Барилгын ажлыг 2018 оны 4 дүгээр сарын 10-

наас эхэлж, 2018 оны 10-р сарын 31-нд хүлээлгэж өгөх ба барилгын санхүүжилтийн 879,827.8 мянган төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 26-нд Хэрэмт цамхаг УТҮГ-ын дансанд орж ирснийг урдчилж орсон орлогоор бүртгэн авсан байна.

Хэрэмт цамхаг УТҮГ нь ШШГЕГ-ын харъяа хорих 407-р ангид материал нийлүүлэх тухай ШШГЕГ-2017/96 дугаар бүхий гэрээг 267,237.5 мянган төгрөгөөр байгуулсан бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл материалыг нийлүүлэхээр гэрээг хийсэн. Материалын үнэ 267,237.5 мянган төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Хэрэмт цамхаг УТҮГ-ын дансанд орсныг урдчилж орсон орлогоор бүртгэсэн байна. ШШГЕГ-аас нийтдээ 1,147,065.3 мянган төгрөг орж ирс

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байх, талаар судлаж үзэхэд Shilendans.gov.mn сайтад 2017 онд 11 төрлийн мэдээлэл оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 7 дансанд нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчилд зөвлөмж өгөв


Нэмэгдсэн өртгийн албан татварын өрийн үлдэгдэл 32,319.6 мянган төгрөгийг төлөөгүй байгаа нь НӨАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 заалтыг зөрчсөн байна. Шийдвэрлэсэн нь: Энэ зөрчил нь Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн /Татварын ерөнхий хууль зөрчих/ 11.19.2, 11.20.4-т заасан хариуцлагыг хүлээх эрсдэл гарч болох тул НӨАТ-ын өрийг барагдуулах зөвлөмж хүргүүлээ.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 онд урдчилж орсон орлого бүртгэгдсэн. Өвөрхангай аймагт баригдах ШШГГ-ын нэг цонхны үйлчилгээ, цагдаа хорих байрны санхүүжилт 879,827.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 2018 онд



хийгдэх тул барилгын зураг, төсөв, гүйцэтгэлийн явцыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн ШШГЕГ-ын харъяа хорих 407 ангид барилгын материал нийлүүлэхээр хийсэн 267,237.5 мянган төгрөгийн гэрээний гүйцэтгэлийг хянаж, материал нийлүүлэлтийн гүйцэтгэл, борлуулалтын дүнг анхаарч үзэх нь зүйтэй.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Хэрэмт цамхаг” 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 32,3 сая төгрөгийн НӨАТ-ыг хуулийн хугацаанд төлөөгүй татварын өр үүссэн зөрчил илэрсэн ба 32,3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд “Амгалан ахуй Аудит ХХК аудит хийсэн бөгөөд аудитаар акт, албан шаардлага гаргаагүй байна. ААНОАТ-ын хуулийг хэрэгжүүлэх, санхүүгийн болон орлогын татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журмыг мөрдөх зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, 2017 оны ААНОАТ-ын тайланд элэгдлийн зардлын зөрүүг тооцоолж тайланг гаргасан байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Төлөвлөлтийн үе шатанд ТАБ-СТА-А-1 маягыг ашиглан материаллаг түвшинг тогтооходоо борлуулалтын орлогыг суурь үзүүлэлт болгон сонгосон бөгөөд 1 хувиар буюу 6,617.9 мянган төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Татварын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Нэмэгдсэн өртгийн албан татварыг татвар төлөх хуулийн хугацаанд төлөөгүй 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 32,319.6 мянган төгрөгийн татварын өр үүссэн нь НӨАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 заалт/ Нэмэгдсэн өртгийн албан татварыг дараа сарын 10-ны дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 11.19.2, 11.19.14-т заасан хүү, торгуулийн хариуцлага хүлээх

ҮАГ-ын зөвлөмж

НӨАТ-ын дутуу төлөлтийг 2018 оны 04 дугаар сарын 10-ний дотор төлж барагдуулах. Цаашид албан татварыг хуулийн хугацаанд нь төлж байхыг зөвлөж байна.

Төсвийн захирагчийнхариу


Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4.1 Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	361,914.67	1,153,769,698.71
Дансны авлага	90,390,614.40	91,665,964.40
Татвар НДШ авлага		56,519.00
Бусад авлага	202,800.00	1,084,000.00
Бараа материал	155,506,410.55	31,248,829.83
Урдчилж төлсөн зардал		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бусад хөрөнгө		152,475,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	246,461,739.12	1,430,300,011.94
Үндсэн хөрөнгө	900,338,369.03	764,862,039.94
Биет бус хөрөнгө	1,370,448.72	998,525.64
Биологийн хөрөнгө		
Уртхугацат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдөлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	901,708,817.75	765,860,565.58
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,147,170,556.87	2,196,160,577.52
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	32,773,077.18	30,851,141.54
Цалингийн өглөг		
Татварын өр	14,850,801.42	32,319,638.39
НДШ –ийн өглөг		
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урдчилж орсон орлого		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,623,878.60	302,102,360.43



Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацат өр төлбөр		
УРТХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	47,623,878.60	1,210,236,095.43
ЭЗДИЙН ӨМЧ		
ӨМЧ –төрийн	161,096,688.93	161,096,688.93
-Хувийн		
-Хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,297,769,167.27	1,297,769,167.27
Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	(358,319,177.93)	(472,941,374.11)
Тайлангийн үеийн ашиг		(114,622,196.18)
Өмнөх үеийн ашиг	(358,319,177.93)	(358,319,177.93)
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,100,546,678.27	985,924,482.09
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,148,170,556.87	2,196,160,577.52

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	349,361,420.34	587,756,427.29
БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	258,278,748.45	490,802,688.01
НИЙТ АШИГ АЛДАГДАЛ	91,082,671.55	96,953,739.28
Түрээсийн орлого		
Хүүний орлого		
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	1,135,254.55	557,628.07
БУСАД ОРЛОГЫН ДҮН	1,135,254.55	557,628.07
Борлуулалт маркетингийн зардал	2,063,277.00	2,888,595.13
Ерөнхий ба удирдлагын зардал	166,100,054.24	126,818,135.75
Санхүүгийн зрдал		
Бусад зардал		
ЗАРДЛЫН ДҮН	168,100,054.24	126,818,135.75
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз		
Үндсэн хөрөнгө хассаны олз гарз	(663,130.43)	
Биет бус хөрөнгө хассаны олз гарз		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз		
Бусад ашиг алдагдал	(137,069,307.69)	(82,426,832.14)
ОЛЗ ГАРЗЫН ДҮН	(137,732,438.12)	(82,426,832.47)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ АЛДАГДАЛ	(213,614,566.26)	(114,622,196.18)
Орлогын татварын зардал		
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ АЛДАГДАЛ	(213,614,566.26)	(114,622,196.18)
Зогсоосон үйл ажиллагааны дараах ашиг алдагдал		
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ	(213,614,566.26)	(114,622,196.18)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валют хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз гарз		
Нийт орлогын дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг алдагдал		

4.3 АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31 –ээрхи үлдэгдэл	161,096,688.93	1,297,769,167.27	(144,704,612.01)	1,314,161,244.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	
Тайлант үеийн үр дүн/цэвэр ашиг, алдагдал/	-	-	(213,614,565.92)	(213,614,565.92)
2016 оны 12-р сарын 31-ээрхи үлдэгдэл	-	-	-	
2017 оны 01-р сарын 01-ээрхи үлдэгдэл	161,096,688.93	1,297,769,167.27	(358,319,177.93)	1,100,546,678.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	
Тайлант үеийн үр дүн/цэвэр ашиг, алдагдал/			(114,622,196.18)	(114,622,196.18)
2017 оны 12-р сарын 31-ээрхи үлдэгдэл	161,096,688.93	1,297,769,167.27	(472,941,374.11)	985,924,482.09



4.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	282,898,376.50	1,608,997,633.14
Борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний орлого	275,993,392.50	428,189,950.00
Эрхийн шимтгэл, хураамж , төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	6,904,984.00	1,180,807,683.14
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	353,330,060.41	355,589,849.10
Ажиллагчдад төлсөн	99,801,561.58	106,729,162.20
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,617,392.10	2,135,283.48
Бараа материал худалдан авахад төлсөн	111,273,140.00	182,170,782.34
Ашиглалтын зардалд төлсөн	6,221,969.97	9,582,196.21
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	20,309,010.90	33,054,716.66
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	7,654,245.60	16,533,923.21
Даатгалын төлбөрт төлсөн	684,990.00	
Бусад мөнгөн зарлага	105,767,750.26	5,383,785.00
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(70,431,683.91)	1,253,407,784.04
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,000,000.00	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урдчилгааны орлого	23,000,000.00	
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Бусад		
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	11,435,170.00	
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	435,170.00	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урдчилгаа олгосон	11,000,000.00	
Бусад		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	11,564,830.00	
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		
Зээл авсан , өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан орлого		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасны орлого		
Төрөл бүрийн хандив		
Бусад		
МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	43,000,000.00	100,000,000.00
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад	43,000,000.00	100,000,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-43,000,000.00	-100,000,000.00
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(101,866,853.91)	1,153,407,784.04
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,228,768.58	361,914.67
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	361,914.67	1,153,769,698.71

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**